

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч	-Нийслэлийн ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Энхтөр
Гишүүд:	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр; -Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга Э.Анар; -Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг; -Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр; -Нийслэлийн Статистикийн газрын дарга Д.Лхамсүрэн; -Нийслэлийн Татварын газрын дарга Д.Мөнх-Учрал; -Багануур дүүргийн Засаг даргын орлогч Т.Отгонболд; -Багахангай дүүргийн Засаг даргын орлогч Б.Болормаа; -Баянгол дүүргийн Засаг даргын орлогч Э.Батбилэг; -Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч Т.Батцогт; -Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалаг; -Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч О.Ганбаатар; -Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч Ц.Шижир; -Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч Г.Батсайхан; -Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч Ж.Лхагвасүрэн; -“Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” ОНӨҮГ-ын дарга Д.Баярсайхан.
Нарийн бичгийн дарга	-Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газрын дарга Б.Бат-Эрдэнэ.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан, дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Энхтөр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД